# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр Дугаар 347 Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн нийт 696,807,749.26 (зургаан зуун ерэн зургаан сая найман зуун долоон мянга долоон зуун дөчин есөн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 42,306,184.78 (дөчин хоёр сая гурван зуун зургаан мянга нэг зуун наян дөрвөн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал М.Ганбаатар, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

000679

D:\Huraldaanii material\2020 on\2020.07.06 11r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
347 дугаар тогтоолын хавсралт

## "ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр | | Ашиглалтанд орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | К-5 Зуухны их бие | Спирал/кокс/ тээвэрлэгч | 1/1/2017 | ш | 2 | 55,722,015.96 | 111,444,031.92 | 6,766,244.80 | 104,677,787.12 |
| 2 | | Спирал/кокс/ тээвэрлэгч | 1/1/2017 | ш | 3 | 30,869,385.58 | 92,608,156.74 | 5,622,638.09 | 86,985,518.65 |
| 3 | | Спирал/кокс/ тээвэрлэгч | 1/1/2017 | ш | 3 | 30,227,104.96 | 90,681,314.88 | 5,505,651.26 | 85,175,663.62 |
| 4 | | Спирал/кокс/ тээвэрлэгч | 1/1/2017 | ш | 1 | 35,556,511.72 | 35,556,511.72 | 2,158,788.21 | 33,397,723.51 |
| 5 | | Зуухны коксын бункер | 1/1/2017 | ш | 1 | 366,517,734.00 | 366,517,734.00 | 22,252,862.42 | 344,264,871.58 |
| Нийт дүн | | | | | | | **696,807,749.26** | **42,306,184.78** | **654,501,564.48** |
| | | | | | | | **(зургаан зуун ерэн зургаан сая найман зуун долоон мянга долоон зуун дөчин есөн төгрөг хорин зургаан мөнгө)** | **(дөчин хоёр сая гурван зуун зургаан мянга нэг зуун наян дөрвөн төгрөг далан найман мөнгө)** | **(зургаан зуун тавин дөрвөн сая таван зуун нэгэн мянга таван зуун жаран дөрвөн төгрөг дөчин хоёр мөнгө)** |